



## БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 06 сарын 02 өдөр

Дугаар А/377

Булган сум

┌ Засаг даргын нөөц хөрөнгөөс тусламж, ┐  
дэмжлэг олгоход баримтлах журам батлах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Засаг даргын нөөц хөрөнгөөс нэг удаагийн тусламж, дэмжлэг олгоход баримтлах журмыг хавсралтаар баталсугай.


2.Журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Наранбаяр)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР



06  
A/377  
Аймгийн Засаг даргын 2025 оны  
дугаар сарын 02-ны/ний өдрийн  
... дугаар захирамжийн хавсралт



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН НӨӨЦИЙН ХӨРӨНГӨӨС ТУСЛАМЖ,  
ДЭМЖЛЭГ ОЛГОХОД БАРИМТЛАХ ЖУРАМ**

2025 оны 06 дугаар сарын 02

Булган сум

**Нэг.Нийтлэг үндэслэл:**

1.1.Энэхүү журмын зорилго нь Засаг даргын нөөц хөрөнгөнөөс Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Төсвийн тухай хууль, Иргэдээс төрийн байгууллага албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт зарцуулалтын нийтлэг журам болон бусад холбогдох хууль тогтоомжид заагдсан аймгийн Засаг даргын бүрэн эрхтэй зөрчилдөхгүй, урьдчилан төсөвт тусгах боломжгүй боловч зайлшгүй хэрэгжүүлэх үйл ажиллагааг санхүүжүүлэх зардал буюу иргэд, хуулийн этгээдэд нэг удаагийн тусламж, дэмжлэг үзүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2.Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт зарцуулалтын нийтлэг журамд заасан тусламж дэмжлэгийг иргэд, байгууллагад олгох хэмжээг тодорхойлон тогтооно.

1.3.Нэг төрлийн тусламж, дэмжлэгийг иргэн, байгууллагад тухайн төсвийн жилд давхардуулан олгохгүй. Өөрөөр хэлбэл нэг иргэн, байгууллага тухайн жилд нэг удаа нөөц хөрөнгөөс тусламж, дэмжлэг авах эрхтэй.

**Хоёр.Хөрөнгийн эх үүсвэр:**

2.1.Аймгийн төсөвт тусгагдсан Засаг даргын нөөц хөрөнгийн эх үүсвэрээс хууль тогтоомжийн дагуу захиран зарцуулна.

**Гурав.Тусламж, дэмжлэг авахад бүрдүүлэх баримт,  
хүлээн авах, шийдвэрлэх:**

3.1.Тусламж дэмжлэг хүссэн өргөдөл, хүсэлтийг нотлох баримтын хамт Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны, удирдлагын хэлтэст ирүүлнэ. Хариуцсан ажилтан нь өргөдөл, хүсэлтийг цахим санд бүртгэн давхардал гаргахгүй ажиллана.

3.2.Өргөдөл, хүсэлтийг хариуцсан ажилтан хүлээн авч бүртгэн, шийдвэрийн төслийн танилцуулгын хамт удирдлагын багийн хуралд танилцуулан шийдвэр гаргуулна.

3.3.Нотлох баримт дутуу өргөдөл, хүсэлт нь шаардлага хангаагүй бол холбогдох этгээдтэй холбогдон нэмэлт нотлох баримт гаргуулах, шаардлага хангуулах талаар мэдэгдэх үүргийг асуудал хариуцсан ажилтан гүйцэтгэнэ.

3.4.Энэ журмын 3.3-т заасан үүргээ хэрэгжүүлээгүй иргэн хуулийн этгээдэд тусламж, дэмжлэг үзүүлэхээс татгалзах эрхтэй бөгөөд хариуг бичгээр өгч цахим санд бүртгэнэ.

3.5.Тусламж, дэмжлэг олгох асуудлыг Засаг даргын захирамжаар шийдвэрлэнэ.

**Дөрөв.Иргэд, айл өрхөд олгох тусламжийн төрөл, хэмжээ:**

4.1.Аймгийн Засаг даргаас үзүүлэх тусламж нь тухайн нөхцөл байдлаас шалтгаалан дараах төрөл, хэмжээтэй байна.

4.1.1.Гамшиг, осолд нэрвэгдсэн айл өрх,иргэдэд учирсан хохирлын хэмжээнээс шалтгаалан нэг удаа 5,000,000 (таван сая) төгрөг хүртэл

4.1.2.Аймагтаа эмчлүүлэх боломжгүй дараагийн шатлалын эмнэлэгт явж эмчлүүлэх тохиолдолд өвчний онош хүндрэл зэргээс шалтгаалан нэг удаа 5,000,000 (таван сая) төгрөг хүртэл

4.1.3.Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт зарцуулалтын нийтлэг журамд заасан төрлийн тусламжид нэг удаа 5,000,000 (таван сая) төгрөг хүртэл

#### **Тав.Байгууллага, аж ахуйн нэгжид олгох дэмжлэгийн төрөл, хэмжээ:**

5.1.Аймгийн Засаг даргаас олгох дэмжлэг нь дараах төрөл, хэмжээтэй байна.

5.1.1.Урлаг, соёлын уралдаан, тэмцээн зэрэг арга хэмжээний санхүүжилтийг тухайн байгууллагын болон Засаг даргын төсөвт тусгагдаагүй зардалд нэг удаа 10,000,000 (арван сая) төгрөг хүртэл

5.1.2.Спортын арга хэмжээ уралдаан тэмцээн, бусад арга хэмжээний санхүүжилтийг тухайн байгууллагын болон Засаг даргын төсөвт тусгагдаагүй зардалд нэг удаа 10,000,000 (арван сая) төгрөг хүртэл

5.1.3.Төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах, техник, тоног төхөөрөмж авахтай холбоотой тухайн байгууллагын төсөвт тусгагдаагүй цаг үеийн шинжтэй зардалд 5,000,000 (таван сая) төгрөг хүртэл

5.1.4.Гамшгаас хамгаалах, давагдашгүй хүчин зүйлээс шалтгаалсан эрсдэл учирсан, учрахаас урьдчилан сэргийлэх төсөвт тусгах боломжгүй зардалд 5,000,000 (таван сая) төгрөг хүртэл

5.1.5.Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт зарцуулалтын нийтлэг журамд заасан төрлийн дэмжлэгт 3,000,000 (гурван сая) төгрөг хүртэл

#### **Зургаа. Тусламж, дэмжлэгийг олгох, тайлагнах:**

6.1.Тусламж дэмжлэгийг Засаг даргын нөөцийн төсөвт нийцүүлэн энэ журамд заасан хэмжээнд багтаан ажлын 3 өдрийн дотор Засаг даргын захирамжаар олгоно.

6.2.Засаг даргын нөөц хөрөнгийг захиран зарцуулах эрхийг Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга хэрэгжүүлнэ.

6.3.Тусламж, дэмжлэгийн хөрөнгийн зарцуулалтын тайланг Аймгийн Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч хариуцан улирал тутамд удирдлагын багийн хуралд танилцуулна.

#### **Долоо.Бусад:**

7.1.Нөөцийн хөрөнгөөс тусламж, дэмжлэг олгохтой холбоотой асуудлаар гарсан маргааныг зөвшилцлийн замаар харилцан ойлголцож шийдвэрлэнэ.

7.2.Маргааныг зөвшилцлийн замаар шийдвэрлэх боломжгүй тохиолдолд хуулийн байгууллагаар шийдвэрлүүлнэ.

7.3.Нөөцийн хөрөнгөөс тусламж, дэмжлэг олгох журмыг зөрчиж, давхардал гаргасан хэмжээг зөрчсөн албан тушаалтанд Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.